

Монгол Улсын Үндэсний аудитын газар

ҮАГ

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2005 оны 3 дугаар сар

ТӨСӨВТ ЗАРДЛЫГ ХЭТРҮҮЛЭН ЗАРЦУУЛЖЭЭ

Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагын 2004 оны санхүүгийн үйл ажиллагаа, төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт	2
	Аудитын хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаархи мэдэгдэл	2
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	2
Аудитын дүн	Төсвийн хөрөнгийн зарцуулалт, өөрийн орлогын бүрдүүлэлт	4
	Хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт	6
	Санхүүгийн тайлагнал	7
	Өр, авлага, сангийн талаар	8
	Хөрөнгийн үнэлгээний талаар	9
Дүгнэлт		11
Холбогдох байгууллагын санал	Гадаад хэргийн яамны санал	12
Зөвлөмж		13

Ерөнхий зүйл

Аудитын зорилт УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2004 оны 8/983/2572 дугаар албан бичиг, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2004 оны санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийв.

Дараахь чиглэлээр шалгаж дүгнэлт, зөвлөмж өгөхөд аудитын зорилт оршив. Үүнд:

- Төсвийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт
- Өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт
- Хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт
- Сангийн бүрдүүлэлт, зарцуулалт
- Санхүүгийн тайлагнал

Аудитын хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагын 2004 оны санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлтэй холбоотой баримт материалд үндэслэн хийв.

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд тусгагдсан аудитын арга зүйг ашигласнаас гадна судалгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд чиглэгдсэн аудитын горимыг гүйцэтгэлээ.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитад дараахь хууль эрхийн актын холбогдох заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль
- Дипломат албаны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 174 дүгээр тушаалаар батлагдсан “Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журам”
- Бусад холбогдох хууль эрхийн акт

Ерөнхий зүйл

Аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн ахлах аудитор Г.Цэдэнбалжир, шинжээч Ц.Цолмон нар 2005 оны 1 дүгээр сарын 24-нөөс 3 дугаар сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудитын дүн

Төсвийн хөрөнгийн зарцуулалт, өөрийн орлогын бүрдүүлэлт

Гадаад хэргийн яам 2004 онд улсын төсвөөс 335,4 сая төгрөг авч, өөрийн орлогоор 55.0 сая төгрөг олохоос улсын төсвийн санхүүжилтийг бүрэн авч, визийн наадаг хуудаснаас 196,4 сая, түрээс, паспортын торгууль болон бусад орлогоос 8,6 сая, нийт 205,0 сая төгрөгийн орлого олжээ.

Тус яам гүйцэтгэлээр 547,9 сая төгрөг зарцуулж, төлөвлөсөн зардлыг 157,5 сая төгрөг буюу 40,3 хувиар хэтрүүлэн зарцуулжээ. Зардлын хэтрэлтийг авч үзвэл:

- Бичиг хэргийн зардлыг 23,6 сая төгрөг,
- Гэрэл цахилгааны зардлыг 2,0 сая төгрөг,
- Тээвэр шатахууны зардлыг 4,1 сая төгрөг,
- Шуудан, холбооны зардлыг 8,0 сая төгрөг,
- Гадаад арга хэмжээний зардлыг 70,6 сая төгрөг,
- Ном, хэвлэл авах зардлыг 2,6 сая төгрөг,
- Урсгал засварын зардлыг 15,6 сая төгрөг,
- Төлбөр хураамж болон бусад зардлыг 9,0 сая төгрөг,
- Гадаад зочны зардлыг 30,3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Үүнээс зөвхөн гадаад арга хэмжээ, гадаадын зочны болон бичиг хэргийн зардал 124,5 сая төгрөгөөр хэтэрсэн нь нийт зардлын хэтрэлтийн 75,1 хувийг эзэлж байна.

Үүнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга гадаад оронд айлчлах ажиллагааг зохицуулах, урьдчилан бэлтгэх үүднээс тус яамны зохих албаны ажилтнууд төсөв, төлөвлөгөөнөөс гадуур томилолтоор ажилласан нь нөлөөлжээ.

Нөгөө талаар гадаад арга хэмжээний зардлыг төрийн өндөрлөгүүдийн гадаад оронд хийх айлчлалтай уялдуулан төлөвлөж чадахгүй байна. Дээрх зардал 2003 онд 124,0 сая төгрөгөөр хэтэрч байжээ.

ГХЯ-ны төсөвт олон улсын байгууллагын гишүүний татвар 454.1 сая төгрөгөөр батлагдсан боловч гүйцэтгэл нь ГХЯ-нд биш СЭЗЯ-нд гардаг байна.

Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын өөрийн орлогын төлөвлөгөөг Санхүү, эдийн засгийн сайд, Гадаад хэргийн сайдын 2004 оны 16/02 дугаар тушаалаар гадаад орнуудаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, олон улсын байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлэх, байр түрээслэх түрээсийн орлогоос 1057,8 сая төгрөгөөр тогтоосноос гүйцэтгэлээр бүгд 1168,9 сая төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөөг 111,1 сая төгрөг буюу 10,5 хувиар давуулан биелүүлжээ.

Аудитын дүн

ДБУААГ-ын үйл ажиллагаанд 933,4 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1107,3 сая төгрөгийн зардал гарч, 173,9 сая төгрөг буюу 18,6 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал;

- Цахилгааны зардал 52,0 сая төгрөг,
- Шуудан холбооны зардал 12,2 сая төгрөг,
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 223,3 сая төгрөг,
- Сэлбэгийн зардал 47,0 сая төгрөг,
- Ариун цэврийн зардал 2,5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

ДБУААГ-ын аж ахуйн тооцоотой гуанз, барилга, Дипломат-95, үйлчилгээний төв өөрийн орлогоор 236,7 сая төгрөг олж төлөвлөгөөг 2,4 сая төгрөг буюу 1,0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Эдгээр нэгжийн урсгал зардалд гүйцэтгэлээр 218,7 сая төгрөг зарцуулж төлөвлөснөөс 14,9 сая төгрөгөөр хэтрүүлжээ. Энэхүү хэтрэлт нь төлөвлөгдөөгүй 14,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.

Дипломат төлөөлөгчийн газрууд 2004 онд 3731,4 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 5968,4 сая, үндсэн бус үйл ажиллагаанаас 457,8 сая, байгууллагын өмчтэй холбогдсон (зочид буудлын орлого, байрны түрээс) орлогоос 659,8 сая, тусламжийн орлогоос 52,4 сая, бүгд 7137,6 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөг 3406,2 сая төгрөг буюу 91,2 хувиар давуулан биелүүлжээ.

Монгол Улсаас гадаад орнуудад суугаа 33 ДТГ Санхүү, эдийн засгийн яамнаас баталсан төсвөөр 6923,8 сая төгрөг урсгал зардалд зарцуулахаас гүйцэтгэлээр 7348,2 сая төгрөг зарцуулж, төсөвт зардлыг 17 ДТГ бүгд 424,3 сая төгрөг буюу 6,1 хувиар хэтрүүлэн зарцуулжээ. Тухайлбал;

- Ханой дахь ЭСЯ 10,9 сая төгрөг,
- Брюссель дэх ЭСЯ 12,0 сая төгрөг,
- Улаан-Үд дэх ЕКГ 21,8 сая төгрөг,
- Токио дахь ЭСЯ 88,4 сая төгрөг,
- Парис дахь ЭСЯ 27,3 сая төгрөг,
- Софи дахь ЭСЯ 15,7 сая төгрөг,
- Будапешт дахь ЭСЯ 29,4 сая төгрөг,
- Женев дэх ЭСЯ 34,7 сая төгрөг,
- Вена дахь ЭСЯ 23,9 сая төгрөг,
- Бээжин дэх ЭСЯ 49,6 сая төгрөг,
- Берлин дэх ЭСЯ 110,5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Аудитын дүн

Урсгал зардлын нийт хэтрэлтийн 42.5 хувийг эд хогшил, тоног төхөөрөмж бэлтгэх зардал эзэлж байна.

ДТГазрууд 2004 оны батлагдсан урсгал төсвөөс 82,4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө бэлтгэхээс гүйцэтгэлээр 262,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэж, төсвийг 180,2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсныг төлөвлөгөөнөөс давсан орлогоороо санхүүжүүлсэн байна.

Тухайлбал; Ханой дахь ЭСЯ 16,4 сая, Пхеньян дахь ЭСЯ 17,7 сая, Токио дахь ЭСЯ 45,7 сая, Каир дахь ЭСЯ 13,5 сая, Нью-Йорк дахь БТГ 16,7 сая, Софи дахь ЭСЯ 19,4 сая, бүгд 129,5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь нийт хэтрэлтийн 72,9 хувийг эзэлж байна.

СЭЗЯ-наас баталсан төлөвлөгөөгөөр 2004 онд 7 ДТГ 676,2 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх ёстой. Гүйцэтгэлээр 1434,1 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 757,8 сая төгрөг буюу 2,1 дахин давуулан биелүүлжээ.

Харин Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ 2003 онд улсын төсөвт 84,6 мянган ам.доллар төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас 3,2 мянган ам.доллар төвлөрүүлсэн бол, 2004 онд улсын төсөвт 22,8 сая төгрөг төвлөрүүлэхээс нэг ч төгрөг төвлөрүүлэлгүй аж ахуйн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Гадаад орнуудад суугаа ДТГ-уудын 2004 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн тодруулгаар касс, харилцах дансанд бүгд 2440,4 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь орлогын төлөвлөгөөг бодитой бус төлөвлөснөөс шалтгаалжээ. Тухайлбал:

Брюссель дэх ЭСЯ 219,1 сая, Парис дахь ЭСЯ 138,4 сая, Бээжин дэх ЭСЯ 263,9 сая, Берлин дэх ЭСЯ 130,2 сая, Сөүл дэх ЭСЯ 640,5 сая төгрөг, Лондон дахь ЭСЯ 116,1 сая, Эрээн дэх ЕКГ 143,1 сая төгрөг, бүгд 1651,3 сая төгрөг буюу нийт мөнгөн хөрөнгийн 67,6 хувь болж байна.

Хөрөнгө
оруулалт,
түүний
зарцуулалт

ГХЯ, Дипломат төлөөлөгчийн газруудын хөрөнгө оруулалтын асуудлыг ДБҮААГ давхар хариуцан гүйцэтгэж ирсэн бөгөөд СЭЗЯ-ны баталсан хуваарийн дагуу хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2004 онд 296,0 сая төгрөг авч Монгол Улсаас гадаад оронд суугаа 13 ЭСЯ болон Консулын газруудад автомашин болон үндсэн хөрөнгө худалдаж авах, барилга засварын ажилд зориулж 320,0 сая төгрөг шилжүүлжээ.

ГХЯ компьютер, принтер тус бүр 15 ширхэгийг авахад 14,9 сая төгрөг, ДБҮААГ барилгын засварт зориулж 27,0 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэх 19,6 сая төгрөгийг Төв төрийн санд буцаан төвлөрүүлжээ.

Аудитын дүн

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Солонгосын ОУХАБ, Турк улсаас болон Төрийн захиргааны шинэчлэлийн төслөөс бүгд 41,2 сая төгрөгийн компьютер, принтер, канон, дэлгэц зэрэг техник хэрэгслийн буцалтгүй тусламжийг ГХЯ-нд олгосныг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

ГХЯ Монгол Улсаас БНХАУ-ын Эрээн хот дахь Консулын газрын барилгыг ТЕГ-ын харьяа “Барилга импекс” УҮГ-аар 300,0 сая төгрөгөөр бариулахаар гэрээ хийжээ. Тус байгууллага нь уг барилгын зураг төсөл, барилга угсралтын ажлыг БНХАУ-ын Хөх хотын “Пайли” компаниар гүйцэтгүүлсэн байна.

Гэрээнд зааснаар ГХЯ-наас барилгын ажлын 5 удаагийн үе шатны гүйцэтгэлээр 273,0 сая төгрөг, Эрээн хот дахь Консулын газраас 600,0 мянган юань буюу 84,6 сая төгрөг, бүгд 357,6 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Гүйцэтгэлийн аудитын явцад ДБҮААГ-ын удирдлага, ТЕГ-ын холбогдох хүмүүсээс Эрээн хот дахь Консулын газрын барилга, гадаад орчны тохижилтод зориулж олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, мөн Консулын газрын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аудит хийлгэх хүсэлт тавьсан болно. Энэ асуудлыг тусгайлан шалгах шаардлагатай гэж үзэж байна.

Санхүүгийн тайлагнал

ГХЯ, ДБҮААГ, ДТГ анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг үндэслэн тайлан тэнцлээ хугацаанд нь гаргасан боловч ГХЯ-ны санхүүгийн тайланд анхан шатны баримтын бүрдэл дутуу гарч байна. Тухайлбал:

- “Төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцлөөр ашиглуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 282 дугаар тогтоолоор Монгол Улсын дипломат болон албан гадаад паспортыг нууцлал, чанар сайтай хэвлүүлэх, Монгол Улсад нэвтрэх визийн хуудсыг олон улсын шаардлагад нийцүүлэн хэвлүүлэх зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт зориулж нийтдээ 415,6 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөс эргэж төлөгдөх нөхцлөөр Гадаад хэргийн яаманд олгожээ.

ГХЯ 2002-2003 онд 119 сая төгрөг, 2004 онд 273 сая төгрөгийг буцаан төлж оны эцэст 23,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсныг Сангийн яамтай тооцоо хийж, акт үйлдэж уг үлдэгдлийг тайлан тэнцэлд өглөгөөр тусгажээ.

Энэхүү паспортын наадаг хуудас хэвлүүлсний төлбөрийг тайлан тэнцэлд төсвийн байгууллага гэдгээр өмнө нь тусгадаггүй байжээ.

Аудитын дүн

- ГХЯ-ны ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Мишигдоржийн цохолтоор 2003.03.18-ны өдөр БНСУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-нд бэлэг дурсгалын зүйл авахад зориулж, ГХЯ-ны ажилтан Б.Цэрэндоржоор 200 ам.доллар олгосон боловч байгууллага хооронд 2 жил гаруй тооцоо хийлгүй явж иржээ.
- ДБҮААГ-аас ГХЯ-ны удирдлага болон ажилтнуудад суудлын автомашинаар үйлчилсний хөлсний хоорондын тооцоог хийхдээ тайлант хугацааны гүйлгээний дүнгээр тооцоо нийлсэн бөгөөд оны эцсийн үлдэгдэл нь 41.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
- Санхүү эдийн засгийн сайд, Гадаад хэргийн сайдын 2004 оны 16/02 дугаар тушаалын 2-т “Гадаад орноос Монгол улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын болон бусад байгууллага иргэдэд үзүүлэх үйлчилгээний зардлыг нөхөх, эдгээр байгууллагын дулаан, эрчим хүч, ус, бусад үйлчилгээний хөлсийг үйлчлүүлэгч байгууллагуудад зохих журмын дагуу төлөх, төрийн өмчийн байрны засвар хийх зэрэг Дипломат байгууллагуудыг үйлчлэхэд шаардагдах санхүүжилтийн тооцоо, үндэслэлийг харгалзан дээрх үйлчилгээний төлбөрөөр цуглуулсан орлого болон байрны түрээсийн орлогын 40 хувийг ДБҮААГ-ын мэдэлд, үлдэх 60 хувийг улсын төсөвт төвлөрүүлж байх” гэж заасныг үндэслэн харилцах дансаар орсон орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх мөнгийг төвлөрүүлжээ.

Гэвч ДБҮААГ 2004 онд Монгол Улсад суугаа БНКУ, БНАЛАУ-ын ЭСЯ, Франц улсын цэргийн атташе, БНХАУ-ын Жин Мин Жибао сонины сурвалжлагч, Восток нефть газ зэрэг олон улсын байгууллагын ажилтнуудад эзэмшүүлсэн байрны түрээсийн төлбөрийн 25.3 сая төгрөгийг касст бэлнээр тушаасныг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт бичлээ. Уг төлбөрийг ДБҮААГ гүйцэтгэлийн аудитын явцад бүрэн барагдуулжээ.

Өр, авлага, сангийн талаар ДТГ-уудын 2004 оны тайлан тэнцлээр 571.2 сая төгрөгийн авлагатай гарснаас Москва дахь ЭСЯ нийт авлагын 72,4 хувийг эзэлж байгаа ба энэхүү авлагын 334.4 сая төгрөг нь 56 байгууллага, аж ахуйн нэгжтэй, 70.7 сая төгрөг нь 64 хүнтэй, 8.4 сая төгрөг нь дараа тайлан гаргагч 20 хүнтэй холбоотой байна.

ДТГ-ууд 2004 оны тайлан тэнцлээр 770.2 сая төгрөгийн өглөгтэй гарснаас Москва дахь ЭСЯ 488.5 сая төгрөг буюу нийт өглөгийн 63,4 хувийг эзэлж байна.

Аудитын дүн

Москва дахь ЭСЯ-ны нягтлан бодогчоор ажиллаж байсан С.Махбал 1998 онд Улаанбаатар хотын шүүхэд зарим өрийн асуудлыг шийдвэрлүүлэхээр албан тоот (1998 оны 3 дугаар сарын 15-ны 116 тоот) явуулсан боловч шүүхийн байгууллагаас баримтын бүрдэлгүй гэж буцааснаас хойш дахин энэ талаар бодитой ажил хийгдээгүй байна.

Тус ЭСЯ-нд мэргэжлийн нягтлан бодогчийг төвөөс томилон ажиллуулдаг атал дээрх өр, авлагыг барагдуулах талаар хангалтгүй ажиллаж иржээ.

ДТГ-уудын санхүүгийн тайланд хавсрагдсан өр, авлагын жагсаалтад тухайн өр, авлага хэдийд, хэрхэн яаж үүссэн нь тодорхойгүй байгаа тул уг авлага, өглөгийн тооцоог холбогдох байгууллагатай хамтран тогтоож, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

ГХЯ-ны 2004 оны тайлан тэнцлийн авлагын үлдэгдлийн 17.4 сая төгрөг нь тус яамны ажилтнуудын дараа тайлангийн тооцоо хийгдээгүй үлдэгдэл байна.

ДБУААГ-ын 2004 оны тайлан тэнцлээр 201,0 сая төгрөгийн авлагаас 104,1 сая төгрөгийн авлага нь өмнөх онуудад үүссэн бөгөөд үүнээс 23.3 сая төгрөгийн авлага нь төлөгдөх найдвар муутай авлагууд байна.

ГХЯ-нд тусгай зориулалтын болон бусад эх үүсвэрээр бүрдсэн сан байхгүй байна.

Харин ГХЯ 2003 оны эцэст Засгийн газрын нөөцөөс хуваарилсан хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл 7,7 сая төгрөг, 2004 онд Буриадын Ерөнхийлөгч, Швед, БНСВУ-ын улсын Ерөнхий сайдын айлчлал, Монгол, Орос, Украин, Куба, Казахстан, Австрийн Засгийн газар хоорондын хуралдаан, Зүүн Азийн орнуудын уулзалтад оролцох Ерөнхий сайд тэргүүтэй төлөөлөгчдийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 11,6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Хөрөнгийн
үнэлгээний
талаар

ДБУААГ 2004 онд Турк, Энэтхэг Улсын ЭСЯ байрлаж буй үл хөдлөх хөрөнгөд “Ситико-Аудит” ХХК-иар үнэлгээ хийлгэхээр гэрээ хийжээ. Гэрээний 3.1-т заасны дагуу ажлын хөлсийг захиалагч, гүйцэтгэгч талууд харилцан тохиролцох журмаар үнэлсэн хөрөнгийн үнэлгээний үнийн дүнгээс Туркийн барилгыг 0,5 хувиар тооцож 5.9 сая төгрөг (1753,2 сая төгрөгөөс), Энэтхэгийн барилгыг 0,34 хувиар тооцож 7.3 сая төгрөг (1476.1 сая төгрөгөөс), бүгд 13.4 сая төгрөг олгогджээ.

Аудитын дүн

“Ситико-Аудит” ХХК-ний санхүүгийн баримтад Энэтхэг улсаас суугаа ЭСЯ-ны барилгыг үнэлэх гэрээнд үнэлгээний хөлсийг 1100,0 мянган төгрөгөөр олгохоор гэрээг эдийн засагч Д.Байгаль хийсэн байна. Өөрөөр хэлбэл гэрээ нь 2 байгууллагад өөр өөр дүнгээр хийгдсэн байна.

Хэрэв тухайн объектыг үнэлсэн үнийн дүнгээс тодорхой хувиар тооцож үйлчилгээний төлбөрийг тооцвол үнэлгээ нь бодит бус байдлаар хийгдэж, улмаар их төлбөр авахын тулд өндөр үнээр л үнэлэгдэх болно гэж үзэж байна.

Дүгнэлт

Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2004 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын явцад олж авсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа тооцоонд тулгуурлан доорхи дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2004 онд Гадаад хэргийн яам төсөвт зардлыг 40,3 хувиар, Дипломат төлөөлөгчийн 17 газар төсөвт зардлыг 6,1 хувиар, Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газар төлөвлөсөн хэмжээнээс 18,6 хувиар тус тус хэтрүүлэн зарцуулжээ.
- ГХЯ-нд Засгийн газрын нөөцөөс олгосон хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй байна.
- ДБҮААГ-аас ГХЯ-ны удирдлага болон ажилтнуудад суудлын автомашинаар үйлчилсэн тээврийн хөлсний хоорондын тооцооны үлдэгдэл 41.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
- ДТГ-уудын 2004 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн 571.2 сая төгрөгийн авлага, 770.2 сая төгрөгийн өглөгийн 63,4-72,4 хувь нь Москва дахь ЭСЯ-нд ногдож байна.
- ГХЯ-ны 2004 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр 17.4 сая төгрөгийн авлагатай гарсан нь дараа тайлан гаргахаар урьдчилгаа авсан ажилтнууд тайлангаа гаргаагүй, санхүүгийн алба тооцоог цаг хугацаанд нь хийхгүй байгаатай холбоотой байна.
- ДБҮААГ-аас Турк, Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-дын барилгад үнэлгээ хийхдээ тухайн объектыг үнэлсэн үнийн дүнгээс тодорхой хувиар үйлчилгээний төлбөрийг тооцсоноос үнэлгээ бодитой бус хийгдсэн бөгөөд гэрээний үнэ зөрүүтэй байна.
- Монгол Улсаас БНХАУ-ын Эрээн хот дахь Консулын газрын барилгын санхүүжилтэд олгосон хөрөнгийн зарцуулалтад тусгайлан аудит хийх шаардлагатай гэж үзэж байна.

Холбогдох байгууллагы санал



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН САЙД

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 7А, Утас: 31-13-11, Факс: 32-21-27,
E-mail: mongmer@magicnet.mn; http://www.extmin.mn

2005.04.19 № 09/1288
танай 2005.04.13 -ны № 116 -т

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ЕРӨНХИЙ АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн багцын 2004 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн болон гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хүлээн авч байна.

Цаашид зөвлөмжид тусгагдсан асуудлын талаар тодорхой ажил зохиож дүнг Танд танилцуулах болно.



Ц.МӨНХ-ОРГИЛ

081533

Зөвлөмж

Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2004 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнг үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд зөвлөмж болгож байна. Үүнд:

- Гадаад хэргийн яам, Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газар, Дипломат төлөөлөгчийн газар төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсанд дүгнэлт хийж холбогдох арга хэмжээ авах;
- Гадаад оронд суугаа Элчин сайдын яамдад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, үндсэн хөрөнгө худалдаж авахдаа батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй байх;
- Засгийн газрын нөөц хөрөнгөөс гадаад арга хэмжээ, айлчлалын үйл ажиллагаанд зориулж олгосон хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж байх;
- Тайлан тэнцлээр ГХЯ, ДБҮААГ-ын хооронд үүссэн маргаантай авлагын үлдэгдлийг шийдвэрлэх;
- Дараа тайлангаар урьдчилгаа мөнгө авсан хүмүүсээр тайлан гаргуулж, зарцуулалт болон үлдэгдлийг тооцож бүртгэлд тусгаж байх;
- Москва дахь ЭСЯ-тай холбоотой авлага, өглөгийг шалган тогтоож, барагдуулах;
- Төлөвлөгөөнөөс давсан орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан, тайлангийн хугацаа хожимдуулсан ЭСЯ болон дипломат төлөөлөгчийн болон консулын газрын удирдлагуудтай хариуцлага тооцох.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

Үндэсний аудитын газрын
Тэргүүлэх аудитор

Д.Ганбилэг